

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ:

Г.БАЛЖИННЯМ

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК



Огноо: 2020.03.24



**НӨӨЦ СЕРВЕР, MS WINDOWS SERVER DATA CENTER ЛИЦЕНЗ ХУДАЛДАН АВАХ
/2 БАГЦ/ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Багц-1 “MS Windows server Data Center 2019 лиценз худалдан авах”

Багц-2 “Диспетчерийн удирдлага мэдээллийн системийн нөөц сервер худалдан авах”

Төслийн дугаар: ДҮТ-2020-02-15

Тендер шалгаруулалтын дугаар: ДҮТ/202001015

Улаанбаатар

2020 он



Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Нөөц Сервер, MS Windows server data center лиценз худалдан авах” тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Уг тендер нь шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул <https://tender.gov.mn> хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020** оны **4** сарын **06**-ны өдрийн **10** цаг **00** минутаас өмнө *Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд* ирүүлнэ.

Үнийн саналыг **2020** оны **4** сарын **06**-ны өдрийн **10** цаг **30** минутад нээнэ.

Тендерийн нээлтэд сонирхсон этгээд оролцох эрхтэй бөгөөд тендерт оролцогч системд нэвтрэн орж тендерийн нээлттэй танилцах эрхтэй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

<https://tender.gov.mn>



Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл

Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) ТООЗ-ны 1.1-д шаардсан материалууд
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.



7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрт заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.



Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь дараах мэдээллийг үнийн саналын хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны санхүүгийн тайланг баталгаажуулж ирүүлэх 2. Борлуулалтын орлого сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жил тухайн тендерийн төсөвт өртгөөс багагүй байх 3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /2018, 2019 он гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн (гэрээ дүгнэсэн) акт, (тухайн 2 жилийн аль нэг жил нь ядаж нэг удаа санал болгох үнийн дүнгээс багагүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх)/ <p>Бусад нэмэлт шаардлага</p> <ol style="list-style-type: none"> 4. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга 5. Улсын гэрчилгээний хуулбар 6. Татварын ерөнхий газрын цахим тодорхойлолт /тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байна./ 7. ШШГЕГ-ын тодорхойлолт 8. Гэрээний үнэ, хугацаанд нийлүүлэх, хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл 9. Бараа нийлүүлэлтийн хуваарь 10. Нийлүүлэх бараа материалын үзүүлэлт 11. Баталгаат хугацааны талаарх мэдээлэл /12 сараас доошгүй байна./ 12. Бусад шаардлагатай материалууд /тоног төхөөрөмжийн фото зураг, танилцуулга, техникийн үзүүлэлтүүд гэх мэт/ 13. НДЕГ-ын тодорхойлолт (өргүй байх) <p>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. Мөн бичиг баримтыг тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн дарааллын дагуу хавсаргаж ирүүлнэ үү.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг Тендер нь Цахим тендер шалгаруулалт журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /https://tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн нууцлалын кодоор нэвтрэн орж цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Холбоо барих утас: 70041371--278 Б.Ангараг</p> <p>Огноо: 2020 оны 4 сарын 06 өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p><i>Монгол улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Засгийн газрын 14-р байр, “Диспетчерийн үндэсний төв ХХК”</i></p> <p><i>5-р давхар 408 тоот өрөө</i></p> <p>Огноо: 2020 оны 4 сарын 06 өдөр</p>



	Цаг: <i>10 цаг 30 минут</i>
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <ul style="list-style-type: none">✓ Багц-1 “MS Windows server Data Center 2019 лиценз худалдан авах”✓ Багц-2 “Диспетчерийн удирдлага мэдээллийн системийн нөөц сервер худалдан авах”

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц-1 “MS Windows server Data Center 2019 лиценз худалдан авах”

Нийлүүлэгдэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

1. MS windows Server DataCenter Edition-ийн лиценз 1 /нэг / ширхэг	
2.1 Техникийн шаардлага:	
Загвар	<ul style="list-style-type: none">Microsoft Windows Server 2016 R2 Data center x64 (2CPU) - түүнээс дээш
Үйлдвэрлэгч	<ul style="list-style-type: none">Microsoft болон түүнтэй дүйцэхүйц
Лицензийн төрөл	<ul style="list-style-type: none">Биет эсвэл виртуал серверийн 1 лиценз хугацаагүй
Лицензийн тоо	<ul style="list-style-type: none">1 компьютер
Лицензийн хугацаа	<ul style="list-style-type: none">Хязгааргүй
Програмын огноо	<ul style="list-style-type: none">2016 эсвэл 2019 - түүнээс дээш
Баталгаат хугацаа	<ul style="list-style-type: none">1 жил

Багц-2 “Диспетчерийн удирдлага мэдээллийн системийн сервер худалдан авах”

2. Сервер компьютер 1 /нэг/ ширхэг	
1.1 Техникийн шаардлага:	
Загвар	<ul style="list-style-type: none">Dell PowerEdge R740 2U Rackmount server болон түүнтэй дүйцэхүйц
Ашиглалт	<ul style="list-style-type: none">Шинэ байх
Процессор	<ul style="list-style-type: none">Intel Xeon Gold 6128 3.4G, 6C/ 12T, 10.4GT/s, 19.25M Cache, Turbo, HT (115W) DDR4-2666 – ба түүнээс дээш
Санах ой	<ul style="list-style-type: none">2x16GB RDIMM, DDR4 - түүнээс дээш
Диск төрөл	<ul style="list-style-type: none">1x480GB SSD, 4x1.2TB 10K RPM SAS 12Gbps 512n 2.5in Hot-plug
Дискний удирдлага	<ul style="list-style-type: none">PERC H740P RAID Controller
Сүлжээний карт	<ul style="list-style-type: none">4 ethernet: 4 x 10GE or 2 x 25GE - түүнээс дээш
Power Supply Unit	<ul style="list-style-type: none">750W, Hot plug power supplies with full redundancy
Rack Rails	<ul style="list-style-type: none">Rack mount sliding rails
Chasis	<ul style="list-style-type: none">Chassis with up to 8 x 2.5" SA S/SATA Hard Drives for 1/2CPU
Хэмжээ	<ul style="list-style-type: none">Form factor: Rack (2U) Max depth: 715.5 mm



<p>Үйлдлийн системийн дэмжлэг</p>	<ul style="list-style-type: none"> • Windows Server 2016 (Most recent version) • VMware ESXi • Red Hat Enterprise Linux (RHEL) 7.64 • SUSE Linux Enterprise Server (SLES) • Ubuntu 16.04 and 18.04 • Oracle Linux ver. 7.6 • CentOS
<p>Бусад</p>	<ul style="list-style-type: none"> • Front ports: Video, 2 x USB 2.0, available USB 3.0, dedicated iDRAC Direct Micro-USB • Rear ports: Video, serial, 2 x USB 3.0, dedicated iDRAC network port • Video card: VGA • DVD-RW, SATA • Riser options with up to 8 PCIe Gen 3 slots, maximum of 4 x 16 slots • Тоног төхөөрөмжийг бүрэн чадлаар нь хугацаагүй ашиглахад шаардагдах бусад програм болон лицензийг бүрэн багтаасан байна.
<p>Баталгаат хугацаа</p>	<ul style="list-style-type: none"> • 3 жил хүртэл



БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
MS Windows server 2019 лиценз	Microsoft Windows Server 2016 R2 Data center x64 (2CPU) - түүнээс дээш	1	ширхэг	ДҮТ ХХК-ийн байр /Засгийн газрын ХИВ байр/	Гэрээ байгуулснаас хойш 10 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
Диспетчерийн удирдлага мэдээллийн системийн сервер	Dell PowerEdge R740 2U Rackmount server болон түүнтэй дүйцэхүйц	1	ширхэг	ДҮТ ХХК-ийн байр /Засгийн газрын ХИВ байр/	Гэрээ байгуулснаас хойш ажлын 10 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

ДҮТ ХХК-н гүйцэтгэх захирал Г.Балжинням танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО

ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				



Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>Багц1- 1жил, Багц2- 3 жил</i> байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан тоо]</i> хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |



9. Алданги оногдуулах 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. Барааг хүлээлгэн өгөхдөө холбогдох эрх бүхий албан тушаалтанд бүрэн бүтэн байдал, ажиллагааг шалгуулж, хүлээн авах ажлын хэсгийн зөвшөөрлийг авсан байна.
2. Баталгаат засвар (ГЕН-5) 4.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
Нийлүүлсэн барааны баталгаат хугацаа Багц1-1 жил, Багц2-3 жил байна. Энэ хугацаанд гарсан гэмтлийг нийлүүлэгч өөрийн хөрөнгөөр шуурхай засварлана.
4. Төлбөр (ГЕН – 7) 6.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Урьдчилгаа төлбөр өгөхгүй бөгөөд гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт, мөн гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичиг болон санхүүгийн баримт, бараа хүлээж авсан актыг үндэслэн нэхэмжлэх ирүүлснээс хойш ажлын 10 хоногт багтаан төлнө.



5. Алданги
оногдуулах
(ГЕН - 9)¹

8.1. Алданги оногдуулах хувь: 0.2

Алдангийн нийт дүн: 10%



¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.